

ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ, ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА, "АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ" ТӨҮГ-ЫН ЗАХИРЛЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2016 оны 08 сарын 18-ны өдөр

Дугаар. 1155/A/75

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн "Эрх зүйн байдлын тухай хууль"-ийн 8 дугаар зүйлийн 8.4, "Хилийн боомтын тухай хууль"-ийн 13 дугаар зүйлийн 13.2, 13.4 дэх заалт, "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль" ийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улс хоорондын тээвэрлэлтэд хяналт тавих, харилцан мэдээлэл солилцох журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.
2. Энэхүү журмыг хэрэгжүүлж, биелэлтийг ханггуулж ажиллахыг Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын Шалган нэвтрүүлэх газар /Н.Огтонбаяр/, Автотээврийн Үндэсний төвийн Тээвэр зохицуулалтын газар /Ж.Энхбат/ тус тус үүрэг болгосугай.

АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ



Н.ПУНЦАГ

ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАД, ШИЛЖИЛТ
ХӨДӨЛГӨӨНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА



Д.БОЛД

"Иргэний харьялал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар"-ын дарга, "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын захирын 2016 оны 3 сарын 18-ны өдрийн хамтарсан тушаалын *Ч.Анг* дүгээр хавсралт

УЛС ХООРОНДЫН ТЭЭВЭРЛЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ, ХАРИЛЦАН МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Автотээврийн талаар байгуулсан Монгол улсын олон улсын гэрээ хэлэлцээрийг хэрэгжүүлэх, улс хоорондын зорчигч болон ачаа тээвэрлэлт гүйцэтгэж буй тээврийн хэрэгсэлд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт, шалгалт хийх, мэдээлэл солилцохтой холбоотой харилцааг хамтран зохицуулахад оршино.

1.2. Автотээврийн харилцааны тухай олон улсын хэлэлцээрийг хилийн боомтуудад хэрэгжүүлэх ажлыг Иргэний харьялал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын бус, орон нутаг дахь газар, Шалган нэвтрүүлэх тасаг, Автотээврийн үндэсний төвийн тухайн орон нутгийн Автотээврийн төв, салбар хариуцна.

1.3. Монгол Улсын автозамын боомтын хилийн хяналт шалгалтын бусад ачаа, зорчигч тээврийн хэрэгсэлд шалгалт хийх, хяналт тавих ажиллагааг Иргэний харьялал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын бус, орон нутаг дахь газар болон Шалган нэвтрүүлэх газар хариуцна.

1.4. Хяналт шалгалтын бусад гадна байгаа тээврийн хэрэгсэлд шалгалт хийх, хяналт тавих ажиллагааг Автотээврийн үндэсний төвийн хилийн боомтой аймгийн Автотээврийн төв, салбар, Тээврийн хэлтэс хариуцна.

Хоёр. Автотээврийн үндэсний төвийн эрх, үүрэг

2.1. Монгол Улсын Засгийн газар, хөрш орнуудын Засгийн газар хоорондын автотээврийн харилцааны тухай олон улсын хэлэлцээрийн дагуу хилийн боомтоор нэвтрэх тээврийн хэрэгслийн зөвшөөрөл, таних тэмдэг олгох, тээврийн хэрэгслийн стандартыг мэрдүүлэх ажлыг Автотээврийн үндэсний төвийн тухайн орон нутгийн автотээврийн төв, салбар хариуцаж ажиллах;

2.2. Улс хоорондын байнгын зорчигч болон ачаа тээвэрлэлт гүйцэтгэж буй гэрээт аж ахуйн нэгж, байгууллагын тээврийн хэрэгсэл болон жолоочийн мэдээллийн нэгдсэн сан үүсгэж, Иргэний харьялал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрыг мэдээллээр хангах;

2.3. Улс хоорондын байнгын зорчигч болон ачаа тээвэрлэлт гүйцэтгэж буй аж ахуйн нэгж, байгууллага нь холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн, тээвэрлэлт хийх гэрээт хугацаа дууссан, гэрээг цуцалсан тухай мэдээллийг Иргэний харьялал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газарт тухай бур мэдэгдэж, холбогдох арга хэмжээг авч ажиллах.

Гурав. Иргэний харьялал, шилжилт хөдөлгөөний өренхий газрын эрх, үүрэг

3.1. Улс хоорондын тээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрөл бүхий жолооч, тээврийн хэрэгсэл, түүний таних тэмдэг, баримт бичгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шалгаж, хилийн боомтоор нэвтрүүлэх;

3.2. Монгол Улсын Олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу хилийн боомтоор нэвтрэх зөвшөөрөл, тээврийн хэрэгслийн таних тэмдэг олгогдоогүй эсхүл баримт бичгийн зөрчилтэй тээврийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэхгүй байх;

3.3. Улс хоорондын байнгын зорчигч болон ачаа тээвэрлэлт гүйцэтгэж буй аж ахуйн нэгж, байгууллага нь холбогдох хууль тогтоомж зерчсон, тээвэрлэлт гүйцэтгэх гэрээний хугацаа дууссан, гэрээг цуцалсан талаарх Автотээврийн үндэсний төвөөс ирүүлсэн мэдээллийн дагуу улсын хилээр нэвтрүүлэх тээврийн хэрэгслийн жагсаалтаас хасах;

3.4. Монгол Улсын авто замын боомтуудаар нэвтэрсэн зорчигч болон тээврийн хэрэгслийн мэдээ, судалгааг сар, бүтэн жилээр нэгтгэн дараа сарын 03-ны өдрийн дотор энэхүү журмын хавсралтад заагдсан маягтын дагуу Автотээврийн Үндэсний төвд хүргүүлэх; /маягт 1, маягт 2/


3.5. Автотээврийн талаар байгуулсан Монгол Улсын Олон улсын гэрээ, хэлэлцээр, Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 257 дугаар тогтоолын 3 дугаар заалт "Улс хоорондын зорчигч тээврийн байнгын үйлчилгээний тээврийн хэрэгслийг цагийн хуваарийн дагуу улсын хилийн боомтод оруулан тусгайлан зориулсан урсгалаар хил нэвтрүүлж байх арга хэмжээ авах"-ыг хэрэгжүүлэх.

Дөрөв. Бусад

4.1. Талуудын хилийн боомтод тээврийн хэрэгсэлд хийх хяналт шалгалтыг холбогдох нэгж, албад хамтран батлагдсан удирдамжийн дагуу хийнэ.

4.2. Монгол Улсын авто замын нээлттэй хилийн боомтоор хүнд өвчтөн, амьтан, ургамал, түргэн муудах бараа, материал, аюултай ачаа тээвэрлэж буй тээврийн хэрэгслийг хилээр нэвтрүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шуурхай зохион байгуулна.


-----oo-----



2016 ОНЫ ДУГЭЭР САРД УЛСЫН ХИЛЭЭР НЭВТЭРСЭН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН СУДАЛГАА

Бөхийнхор'

№	Бөхийн нэр	Орсон										Гарсан										Нийт
		Онгоц	Аяла вагон	Судл- вагон	Эгт- гүр	Аяла машин	Судл- машин	Чиргуул	Бусад	Бүгд	Онгоц	Ачва вагон	Судл- вагон	Эгт- гүр	Ачва машин	Судл- машин	Чир- гүр	Бусад	Бүгд			
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20		
1	Алтанбүлэг																					
2	Али Сүрье																					
3	Боршоо																					
4	Сүхбаатар																					
5	Цагааннүүр																					
6	Ханх																					
7	Ульхан																					
8	Тас																					
9	Эрзэнцэв Төнөр зам																					
10	Эрзэнцэв авто зам																					
11	Балтаг																					
12	Булган																					
13	Баянхоншуу																					
14	Бичигт																					
15	Биргээстай																					
16	Гашунгүхийт																					
17	Данан																					
18	Хавангра																					
19	Ханий																					
20	Шилээхүрэй																					
21	Занын Чүд төмөр зам																					
22	Занын Чүд эвто зам																					
23	Бүнт хув																					
24	Чойбалсан																					
25	Өлтий																					
26	Хонд																					
	Бүд																					



2016 ОНЫ ДҮТЭЭР САРД УЛСЫН ХИ
/Босоитоор/